



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

~~Кибер аюулгүй байдлыг хангах журам батлах тухай~~

Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1.5, 13.3, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 396 дугаар тушаал "Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын журам", Монгол улсын засгийн газрын 2023 оны 224 дугаар тогтоол, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140, 147, 357 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн кибер аюулгүй байдлын тогтолцоог бий болгож нэгдсэн удирдлагаар хангах, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гадна болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аюул тохиолдох үед нэн даруй хариу арга хэмжээ авах, засах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор "Кибер аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг тус эмнэлгийн өдөр тутмын цахим мэдээллийн бүхий л үйл ажиллагаанд өндөр хариуцлагатайгаар хэрэгжүүлэн ажиллахыг төвийн бүх түвшний эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тус төвийн кибер аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг удирдлагаар ханган ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Батзориг), эмнэлгийн хэмжээнд мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Мэдээлэл технологийн албаны дарга (Э.Батдорж), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (Б.Бат-Оргил), Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан (Б.Оюунмаа) нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай төсвийг батлагдсан төсвийн хүрээнд гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Ц.Энхбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Э. ГАЛБАДРАХ

Төвийн цахим мэдээллийг дараах байдлаар ангилна.Үүнд:

№	Кибер мэдээллийн ангилал	Хамаарах мэдээллүүд
1.	Нээлттэй мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Тусламж үйлчилгээний талаарх лавлагаа мэдээллүүд; - Үйлчлүүлэгчдэд зориулсан утас, цахим хаяг, хаяг байршлууд зэрэг холбоо барих мэдээлэл; - Эмч, ажилтнуудын овог нэр, зэрэг, дэв, цол, мэргэшсэн байдал зэрэг ерөнхий танилцуулга; - Тасаг, алба нэгжүүдийн танилцуулга, үйлчилгээний талаарх мэдээлэл; - Үзлэг, үйлчилгээний журам, захирлын холбогдох тушаалууд болон удирдлагын шийдвэр; - Цагийн хуваарь, цаг авах үйлчилгээтэй холбоотой мэдээлэл; - Цахим хуудсанд олон нийтэд зориулж байршуулсан мэдээллүүд; - Эрүүл мэндийн зөвлөгөө, сургалт, сурталчилгаа, уриалга, сэрэмжлүүлэг; - Байгууллагын төлөвлөгөө, тайлан; - Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн; - Төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны талаарх мэдээлэл; - Эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үзүүлэлт; - Төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлан; - Бусад төрлийн байгууллагын ил тод байдлыг илэрхийлсэн мэдээ, мэдээллүүд;
2.	Хязгаарлагдмал мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын ажилтнуудад зориулсан мэдээ, мэдээлэл; - Удирдлагаас батлан гаргасан аливаа шийдвэр, захирлын тушаал; - Үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл; - Эмч, ажилтнуудын хувийн хэрэг зэрэг хүний нөөцийн мэдээллийн сан; - Алдаа, эрсдэлийн сан; - Хувь хүнд өөрт нь болон ар гэрийнхэнд нь зориулсан оношилгоо, шинжилгээний хариу, биеийн байдал; - Үзлэг, оношилгоо, шинжилгээний явцын тухай мэдээлэл; - Төвийн үйл ажиллагааны үндсэн болон бусад үзүүлэлтүүд; - Өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүд; - Гэрээ, хэлцлүүд; - Эрх бүхий ажилтны зөвшөөрөлтэй авч болох бусад төрлийн мэдээ, мэдээлэл, сан гэх мэт
3.	Нууц мэдээлэл (шаардлагатай гэж үзвэл онц нууц, маш нууц, нууц гэсэн зэрэглэл тогтоож болно.)	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн систем, программ хангамж болон тоног төхөөрөмжүүдэд хандах, нэвтрэх эрх; - Мэдээллийн серверт нэвтрэх эрх; - Өгөгдлийн санд хандах, нэвтрэх эрх, кодчиллол; - Байгууллагын сүлжээний бүтэц, мэдээллийн технологийн дэд бүтцийг харуулсан аливаа зураг, зураглал, кодчиллол, холбогдох мэдээлэл; - Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийн тохиргоо, тэдгээрт хандах эрх, хамгаалалтын түвшний талаарх мэдээлэл; - Байгууллагад бүртгэлтэй хүн амын сан; - Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээлэл агуулсан өвчний түүхийн, амбулаторийн үзлэгийн гэх мэт өгөгдөл, мэдээллийн сангууд; - Байгууллагын нууцад хамаарах бусад мэдээ, мэдээллүүд, өгөгдлийн сан гэх мэт



- 5.1 Төвийн цахим мэдээллийг зэрэглэлээр нь ангилан ялгаж тэмдэглэхдээ Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалын заалтыг дагаж мөрдөнө
- 5.2 Төвийн кибер аюулгүй байдалтай уялдуулан байгууллагын орчин, өрөө тасалгааг дараах байдлаар бүсчилж ангилна. Үүнд:

№	Цахим мэдээлэл байрлах орчны ангилал	Хамаарах орчин	Хариуцагч
1.	Нээлттэй бүс	<ul style="list-style-type: none">- Цахим бүртгэл- Хүлээлгийн танхим- Уулзалтын өрөө- Зөвлөгөө өгөх өрөө- Нийтийн коридор	- Хариуцсан тасаг нэгжийн удирдлага, нийт ажилтнууд
2.	Нийтэд хаалттай бүс	<ul style="list-style-type: none">- Сахиурын өрөө	- Хариуцсан тасаг нэгжийн удирдлага
		<ul style="list-style-type: none">- Эмч, ажилтнуудын өрөө- Үзлэг, шинжилгээ, тарианы өрөө- Тусгаарлах өрөө- Өвчтөний өрөө гэх мэт эмчилгээ үйлчилгээний зориулалтын өрөө тасалгаа- Хурал уулзалтын өрөө	- Тухайн өрөөг хариуцсан ажилтан
3.	Хаалттай бүс	<ul style="list-style-type: none">- Мэдээллийн серверийн өрөө- Сүлжээний зангилаа свич байршсан өрөө, тасалгаа	- Мэдээллийн технологийн алба
		<ul style="list-style-type: none">- Өрөөнүүд доторх зангилаа төхөөрөмж байрласан хэсэг	- Тухайн өрөөг хариуцсан ажилтан
		<ul style="list-style-type: none">- Агуулах, архив зэрэг	- Нярав болон бусад хариуцсан ажилтан
		<ul style="list-style-type: none">- Дээвэр	- Хариуцсан тасаг нэгжийн удирдлага